

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН БИЗНЕС ИННОВАЦЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЖАЛ ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ТӨГӨЛДӨР

2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

УДИРДАМЖ
“УВ ХАКАТОН” УРАЛДААН ШАЛГАРУУЛАЛТ

Сэдэв:

Нийслэл Улаанбаатар хотын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зохион бүтээх санаа, шийдэл боловсруулах.

Уралдааны зорилго:

Оюутан, залуусын бүтээлч сэтгэлгээ, инновацын шийдэл боловсруулах ур чадвар, салбар дундын хамтын ажиллагааг дэмжих замаар Улаанбаатар хотын тулгамдаж буй асуудлыг технологи, инновац, судалгаа, шинжилгээнд суурилсан шийдлээр шийдвэрлэх санал, санаачилгыг бий болгож, шилдэг шийдлийг хөгжүүлэн бодит хэрэглээнд нэвтрүүлэхэд оршино.

Зохион байгуулагч:

Нийслэлийн Бизнес, инновацын газар

Хамтран зохион байгуулагч:

Шинжлэх ухаан, технологийн их сургууль

Хамрах хүрээ:

ШУТИС-ийн бүрэлдэхүүн, харьяа сургуулийн бакалавр, ахисан түвшний суралцагчид

Оролцогчдод тавигдах шаардлага:

- ШУТИС-ийн бакалавр, ахисан түвшний оюутан байх
- 3-5 хүнтэй баг бүрдүүлсэн байх
- Багт инженер болон технологи, менежментийн чиглэлээр суралцаж буй оюутнууд нэгдэж хамрагдвал давуу тал болно.
- Багт УБ хотоос өөр газарт оршин суудаг хүн байгаа тохиолдолд тус гишүүн цахимаар оролцох боломжтой

Дэвшүүлж буй санаа (Idea), шийдэлд тавигдах ерөнхий шаардлага:

- Тодорхой асуудлыг (problem) шийдвэрлэхүйц бодит шийдэл байх
- Ижил төстэй шийдлээс ялгарах давуу тал, инновац шингэсэн байх
- Шинжлэх ухаан, технологи, бизнесийн шийдэл агуулсан байх
- УБ хотын асуудлыг шийдэж, хэрэгжүүлэх боломжтой байх
- Бусдын оюуны өмчийг зөрчөөгүй буюу хуулбарлаагүй байх

Хэрхэн оролцох:

Багууд сонгосон агуулгын хүрээнд өөрсдийн боловсруулсан гарц гаргалгаа, шийдлээ танилцуулж, зохион байгуулалтын багаас өгсөн болон нэмэлт баталгаат эх сурвалжийн судалгаа болон холбогдох өгөгдлийг ашиглан түүнд суурилсан хамгийн үр дүнтэй, хэмнэлттэй бодит байдалтай уялдсан технологийн шийдлийг боловсруулан оролцоно.

Хугацаа, байршил:

- Уралдаанд нэр дэвшүүлсэн санаа, шийдлийг 2026 оны 6 дугаар сарын 05-ны дотор Google формоор хүлээн авах ба ШУТИС-ийн 8-р байранд 2026 оны 6 дугаар сарын 8,9-ний өдрүүдэд зохион байгуулагдана.
- Менторын өдөр 6 дугаар сарын 08-ны өдөр ШУТИС-ийн хичээлийн 8-р байрны 6 давхарт MUST HUB өрөөнд;
- Танилцуулгын өдөр (Demo day) 6 дугаар сарын 09-ны өдөр ШУТИС-ийн хичээлийн 8-р байрны 12 давхарт Олон улсын эрдэм шинжилгээний хурлын танхимд тус тус зохион байгуулагдана.

Зохион байгуулалт:

- "UB Хакатон" уралдаан нь хакатон зохион байгуулах аргачлал (Registration - Mentor day - Demo day)-ын дагуу явагдана.

Шагнал, урамшуулал:

Шилдэг шийдэл боловсруулсан 2 багийг шалгаруулж урамшуулна.

- I байр, шилдэг шийдэл, санаа – 4,000,000 төгрөг
- II байр, шилдэг шийдэл, санаа – 2,000,000 төгрөг

Шалгарсан баг, инновацын шийдлийг цаашид туршилтын төсөл болгон хөгжүүлэх, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг бүрдүүлнэ.

Шалгаруулалтын дүрэм:

- Оролцогч багууд менторшип сургалтад хамрагдан шийдлээ хөгжүүлнэ.
- Шинэлэг сэтгэлгээнд суурилсан мэтгэлцээн өрнүүлэн өгөгдсөн хугацаанд даалгаврыг зөв зохистой хуваарилан гүйцэтгэнэ.
- Эцсийн шалгаруулалтад багууд шийдлээ (pitch) танилцуулж, шүүгчид үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээ хийнэ. .
- Илтгэл танилцуулах: 8 минут (Demo үзүүлэх хугацаа багтсан)
- Асуулт, хариулт: 5 минут (Шүүгчдийн асуултад хариулах)
- Санамж: Хугацаа хэтэрсэн тохиолдолд шууд зогсоох тул цагаа баримтлахыг анхаарна уу.

Уралдаанд материал ирүүлэх:

- Уралдааны материалыг <https://forms.gle/aMj8jKD8ba9eCFjJ6> хаягаар google form маягтын дагуу ирүүлнэ.

Уралдааны талаар мэдээлэл, тодруулга авах хаяг:

- Бизнес, инновацын газар
- Имэйл: bida.info@ulaanbaatar.mn
- Утас: 94433145